



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 770

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний Тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар нийт 304,756,133.00 (гурван зуун дөрвөн сая долоон зуун тавин зургаан мянга нэг зуун гучин гурван) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал, хариуцлагатай компанийн 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал (Б.Мөнхбат)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй ажиллах;

2.3. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн орлогын улсын төсөвт төвлөрүүлээгүй 2,837,500 (хоёр сая найман зуун гучин долоон мянга таван зуун) төгрөгийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан төвлөрүүлэх;

2.4. Компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй, биетээр байхгүй байгаа, Баян-Өлгий аймгийн Толбо суманд байрлалтай, 2014 онд шатсан, холбооны барилга, Булган аймгийн Бугат суманд байрлалтай, 2019 онд шатсан, холбооны барилгыг Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах Улсын хяналтын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн тус тус данснаас хасах талаар шийдвэрлэх арга хэмжээ авах;

2.5. Компанийн эзэмшилд шинээр олж авсан, бүртгэлгүй 83 ширхэг газар эзэмших эрхийг үнэлж, үндсэн хөрөнгөд бүртгэх арга хэмжээ авах;

123007357

36-r huraldaan.docx

2.6.Компанийн худалдан авах үйл ажиллагааг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай, бүрэн төлөвлөж, зохион байгуулах;

2.7.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.“Компанийн дүрэм”-ийг шинэчлэн батлуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ) -т үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа) -т даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны ... дугаар сарын 25-ны өдрийн
7.70 дугаар тогтоолын хавсралт



“Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай
компанид хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрх зүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Мөрдөж буй журмын дагуу төсөвт төвлөрүүлээгүй түрээсийн төлбөр	2.8	ТӨБЗГ-ын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоол	Тогтоолыг мөрдөж ажиллах
2	Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй бараа, үйлчилгээ худалдан авсан	94.3	ТБОНӨХБАҮХАТ хууль, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.2 дахь заалт	Худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллах
3	Нэмэлт гэрээ хийж батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлсэн	33.3		Батлагдсан төсөвт багтаан худалдан авалт хийж байх
4	Үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй олж авсан	174.3	ТБОНӨТ хуулийн 11.8 дахь заалт, ТӨБЗГ-ын 2019 оны 271-р тогтоолоор батлагдсан журам	Хууль болон холбогдох журмыг мөрдөх
НИЙТ ДҮН:		304,756,133.00 (гурван зуун дөрвөн сая долоон зуун тавин зургаан мянга нэг зуун гучин гурван) төгрөг		